


# МОНГОЛ ГЭРИЙН ҮНЭ ЦЭНЭ


[D.Urantsetseg@must.edu.mn](mailto:D.Urantsetseg@must.edu.mn)

# МОНГОЛ ГЭР ЮНЕСКО-Д БҮРТГЭГДСЭН 23 ДАХЬ ӨВ

2




2013 оны 12 сарын 05- өдөр Азербайжан улсын нийслэл Баку хотноо болсон Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын хорооны ээлжит 8 дугаар хуралдаан болж ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад Монгол улсаас нэр дэвшсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” санал нэгтэйгээр батлагдсан түүхтэй.



Монгол гэр бол Төв Азийн нүүдэлчин ард түмний уламжлалт гэр сууц юм. Монгол гэр 3000 орчим жилийн тэртээгээс одоогийн ерөнхий хэв шинж нь бүрэлдэн, нүүдэлчин хүний амьдралын гол оромж хэрэгцээ болсоор өнөө цагт иржээ. Нүүж суухад хөнгөн, авсаархан, удаан эдлэгддэг, архитектурын онцгой шийдэлтэй, агаарын солилцоо сайтай, халуунд сэрүүхэн, хүйтэнд дулаахан гэх мэт олон тодотголыг гэрт өгсөн байдаг.

Байнгын хэрэгцээний гэр сууцыг хийц, гадаад хэлбэрээр нь монгол, түрэг гэр гэсэн хоёр үндсэн ангилалд хамруулна. Монгол гэрийг халх, ойрад, буриад гэж ялган үздэг.




# МОНГОЛ ГЭРИЙН ХЭЛБЭР ЗАГВАР

1. Эрүкэ
2. Урц
3. Алачуг
4. Өвсөн эмбүүл
5. Бургасан гэр
6. Дэглэй гэр
7. Хошлог
8. Жолом
9. Гишгүүр гэр
10. Шалан гэр
11. Зараан тов
12. Сүйжин гэр
13. Булгаасан гэр
14. Холтсон гэр
15. Тэрэгт гэр
16. Орд гэр
17. Өргөө гэр

# УРЦ ГЭР


5




Урц - сургааг цамхаглаж, түүний дээрээс үйс холтос, эсгий, бугын арьсаар хучсан шовхгор овоохой. Урц нь ой хөвч тайга голлосон Уралын нуруунаас Номхон далайн эрэг хүртэл Сибирь даяар Фин Угор хоёр, Түрэг, Монгол бүлгийн хэлтний дунд тархсан сууц юм. Ёроолын диаметр 3-8 метр байдаг.

# МОНГОЛ ГЭРИЙН ХЭМЖЭЭ

6



Монгол гэрийн том багыг ханаар нь хэмжээлэх хийгээд малчин ардын дунд одоо хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг нь 5, 6 ханат гэр болно. Тэгэхдээ нэг хэмжээний гэр дотроо гурван янз байдаг ба бага, дунд, их таван ханат гэх мэт байх бөгөөд бага таван ханат нь ихээсээ арваад униар цөөн байдаг. XIX зууны эцэс үед жирийн малчны гэр нь дөрвөн ханатай, чинээлэг баячуудын гэр нь 5 ханатай, мөн 8-10 ханатай гэрийг аймгийн хан, хошуу тамгын газар барьж байжээ. Жишээ нь: Их 5 ханатай гэрийн Талбайн хэмжээ: 31,15мкв Голч: 5,8м байдаг.Тооно 150см, унь 2,4м байдаг.



# ГЭРИЙН ЕРӨӨЛ


Түмэн өлзий бүрдсэн  
Төр улсыг бататгасан  
Төгс их жаргалын  
Түвшин сайн өдөр гэж  
Сарын сайныг саатан хүлээж  
Өдрийн сайныг өнжин  
хүлээж  
Өнөөдрийн өдрийг  
Үүрдийн түүхт сайн өдөр  
гэж

Өндөр дэнж дээр  
Өргөөгөө барьж байгаа юм  
байна  
Барьсан газрыг шинжилж  
Баруун зүүн талаас нь харвал  
Барс арслангийн шинжтэй  
Байр байдлыг ажиглавал  
Бадам лянхуа цэцэг шиг  
Бадарч дэлгэрмээр газарт  
Барьсан юм байна.

# МОНГОЛ ГЭР ЦАГИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ НЬ

Малчид үнээ малаа саах, хонь бэлчээх, хотлуулах<sup>8</sup> зэрэгт гэрийнхээ тооноор туссан нарны тусгалаар цагийг баримжаалдаг заншилтай юм. Геометрийн харьцааг практикаар сайн мэддэг ардын гар урчууд угсрахад тохирох нарийн тогтоосон хэмжээтэйгээр гэрийн мод зохион хийжээ. Гэрийн тоононы углуургын тэнхлэгийн хоорондох зай тогтмол байх учраас бариастай гэрийн хананы толгойны хоорондох зай, толгойны тэнхлэгийн хоорондох нумны урт, түүнд харьцангуй тогтмол байдаг байна. Ер нь гэрийн голчийг тоононы голчид, унины уртыг тоононы радиуст, баганы өндрийг хаалганы өндөрт харьцуулсан харьцаагаар гэрийн хэлбэрийг зохицуулдаг.





Зүүн урагш хандуулан барьсан дөрвөн ханатай<sup>9</sup> (тотгон дээрээ дөрвөн уньтай), 60 уньтай гэрийн хоёр унины хоорондох зай зургаан хэмийн өнцөгтэй нь орчин үеийн цагийн хуваарьтай нь яг тохирдог гэж эрдэмтэд үздэг.

Гэрийн хананы толгой, унь, тоононы хүрээнд гаргасан нүх бүрийг 60 жилийн нэрээр нэрлэж, гэрийг дөрвөн зүг, найман зовхисоор тэнцүү хэсэгт хуваан, цагийн зүүний эргэлтийн дагуу хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай гэсэн 12 цагаар тэмдэглэдэг. Энэ мэтээр малчин Монголчууд нар, сар, од гаригийн үзэгдлийн зүй тогтлын талаар хуримтлуулсан туршлагаа орон сууцандаа тусгаж цагийн зайг тодорхойлдог байжээ.

# ДАСГАЛ-2

## ХУУДАС-135

Дараах цээрлэх ёсыг уншаад:

а. Эдгээрийг дагаж мөрдсөнөөр чамд ямар сайн зан чанар төлөвших талаар ярилцаарай. Айлд болон гэртээ орох бүрдээ санан, өдөр тутамдаа мөрдөж хэвшээрэй.

- Босго алхан орохдоо босгонд хөлөө хүргэлгүй, урьдаар заавал баруун хөлөөрөө давж ордог.
- Гэрт орох хүн босгонд торж бүдэрвэл тэр айлд олз орно гэж бэлгэшээнэ. Харин гарахдаа босгонд бүдэрвэл гарз гарав гэж ёрлох тул буцаж гэрт орж, галд аргал, түлш өргөөд гардаг заншил буй.
- Босгон дээр гишгэх, дамнан зогсохыг цээрлэнэ. Үүд заяанд муу гэх буюу өшөө хонзон өвөрлөдөг гэдэг.

б. Дараах загварын дагуу цэгийн оронд нөхөж бичээрэй. Хүснэгт 49

№	Цээр	Тайлбар
1	Гэр дотроос гадагш ус цацаж болохгүй.	Үүдний сахиусыг цочооно гэж цээрлэдэг.
2	Ирж байгаа зочныг үүдээр шагайж харах, зочин ирээд уяан дээр нь бууж байхад ойшоохгүйгээр гэртээ орох буюу уулзаж мэндлэхгүйгээр зөрж гарахыг цээрлэнэ.	.....
3	Гэрийн бүслүүр огтлох, хайчлахыг цээрлэнэ.	Айл гэрийн амгаланг эвдэх, ам бүлийг бусниулах муу ёр гэнэ.
4	Шанагаар юм хутгаад аяга саванд хийхдээ гарынхаа ар тал руу эргүүлж хийх цээртэй.	.....
5	.....	Буцаж гэрт ороод галд, аргал, түлш өргөөд гардаг заншил буй.
6	.....	Хэл ам, хэрүүл шуугиан болохын ёр гэнэ.

в. Асуултад хариулж бичээрэй.

- Дээрх цээрлэх ёсыг мэдэх нь ямар ач холбогдолтой вэ?
- Мэддэггүйгээс ямар алдаа гаргаж байсан байна вэ?
- Цаашид энэ алдаагаа яаж засах вэ?

# **ГЭРИЙН ДААЛГАВАР**

**Сурах бичгийн 134-136  
хуудас уншаад Дасгал-3  
хийж гүйцэтгээрэй**